



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2014 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/202

Сүхбаатар

Төгсөлт, Эрдмийн баяр тэмдэглэн
өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-ийн 6-ын "л", Боловсролын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 232 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд өмчийн хэлбэрийг үл харгалзан цэцэрлэг болон 5, 9 дүгээр ангийн төгсөлтийн арга хэмжээг зохион байгуулахыг хориглосугай.

2. 11 дүгээр анги төгсөгчдийн Эрдмийн баярыг жил бүрийн 5 дугаар сарын 4 дахь долоо хоногийн 5 дахь өдөр тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

3. Сумдын Засаг дарга, бүх шатны боловсролын байгууллагын захирал, эрхлэгч нарт ДААЛГАХ нь:

а. Эрдмийн баярын өдөр ажлын байранд болон ажил, үүрэг гүйцэтгэж байх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн, ёс зүйн зөрчил гаргасан, албан газар, сургууль танхимд архидалт, нийллэг зохион байгуулсан, сургууль төгсөлт, эрдмийн баярыг тэмдэглэхтэй холбогдуулан суралцагчдаас болон эцэг эхээр нь дамжуулан хандив, тусламж, сан бүрдүүлэлтийн зэрэг арга хэлбэрээр зүй бусаар мөнгө татах, бэлэг сэлт авсан албан тушаалтныг ажлаас чөлөөлөх, сургуулийн захиргаанаас багш нартай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах, багшийн багшлах эрхийг хасах арга хэмжээ авах.

б. Эрдмийн баярын арга хэмжээний үеэр сурагчдад согтууруулах ундаагаар үйлчилсэн кафе, бар, зоогийн газар, рестораны үйл ажиллагааг зогсоох, аялал зугаалгаар явагсадыг тээвэрлэсэн жолоочид хариуцлага тооцох эрхийг эрх бүхий албан тушаалтан нарт зөвшөөрөх.

в. Сургууль төгсөлт, Эрдмийн баярыг тэмдэглэхтэй холбогдуулан төгсөгчдөөс мөнгө татан арга хэмжээ зохион байгуулахыг хориглож байгааг төрийн бус байгууллагын удирдлагад үүрэг болгох.

г. Сургууль төгсөлт, Эрдмийн баярыг тэмдэглэх тусгай төлөвлөгөө гарган аймаг, сум, сургуулийнхаа орчны тохижилтыг сайжруулах, зүлэг суулгах, цэцэгжүүлэх, мод тарьж, "Ногоон Сэлэнгэ" хөдөлгөөний хүрээнд төгсөгчдийн төгөл байгуулах, урлагийн тоглолт, биеийн тамирын тэмцээн, уулзалт цэнгүүн зохион байгуулах зэргээр сурагчдын оюуны хэрэгцээг хангах, бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах.

д.Сургууль төгсөлт, Эрдмийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ эцэг эх, иргэдийг өргөнөөр татан оролцуулах.


е.Сургууль төгсөлт, Эрдмийн баярыг тэмдэглэх өдрүүдийг согтууруулах ундаа хэрэглэхгүйгээр тэмдэглэж, гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

ё.Хаврын хуурайшилттай үед суралцагчдад аялал зугаалга зохион байгуулахыг хориглож, түүнд тавих хяналт шалгалт, эргүүлийг тогтмол ажиллуулах.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг бүх сумдын Засаг дарга нар, аймгийн Боловсролын газрын дарга /Д.Загдгочоо/, Цагдаагийн газрын дарга, хурандаа /Ж.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/, Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Б.Ууганбаяр/ нарт даалгаж, тайланг нэгтгэн жил бүрийн 06 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргад танилцуулж байхыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/-д даалгасгай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 123 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Н.БАТДОРЖ